БАТЛАВ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Н.ХОНГОРЗУЛ

**ДОРНОГОВЬ АЙМАГ, ЗАМЫН-ҮҮД СУМ ДОТОРХ 2.1КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖИЛ**

*2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр* *Сайншанд сум*

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймаг, Замын-Үүд сум доторх 2.1км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, нормын дагуу хийх ба дараах шаардлагуудыг бүрэн хангасан байна.

1. Ажил гүйцэтгэх хугацааны график (хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо)-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.
2. Зам, замын байгууламжийн ажлыг зам, замын байгууламжийн норм ба дүрэм /БНбД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.
3. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.
4. Ажлыг техникийн ерөнхий шаардлагын дагуу дулааны улиралд гүйцэтгэнэ.

**Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Авто зам барих, Засварлах тусгай зөвшөөрөлтэй байх.
2. Зам, замын байгууламжийн барилга угсралт, засвар арчлалтыг ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр төвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
3. Гэрээнд тусгагдсан ажил бүрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу гүйцэтгэнэ.
4. Авто замын барилга угсралтын ажлыг авто зам барих ажлын технологийн дарааллын дагуу гүйцэтгэнэ.
5. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.

Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана.

6. Зам, замын байгууламжийн ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг, самбар байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.
7. Барилга угсралтын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах.

8. Дүүргэгч материалын шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори, болон талбайн туршилт шинжилгээг техникийн шаардлагын дагуу хийж ил далд ажлын актад хавсаргах.

9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

10. Гүйцэтгэгч нь барилгын ажлыг ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, салбарын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, салбарын хяналтын улсын байцаагч өөрийн эрхийн дагуу барилгын ажилд хугацаатай албан даалгавар өгөх, торгууль тавих, тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

**Тендерийн материалд тавигдах шаардлага:**

1. Төсвийн тооцоог “Авто замын барилгын ажлын жишиг норм” БНбД 81-25-07, Авто зам, замын байгууламжийн засварын ажлын төсвийн жишиг норм БНбД 81-26-08 суурь нормууд болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн 256 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм” ЗЗБНбД 81-013-2019-ыг ашиглан хийж гүйцэтгэнэ.

2. Ажилчдын тарифт цалинг “Зам, тээврийн хөгжлийн сайд”-ын 2019 оны 256 дугаар тушаалаар батлагдсаны дагуу ажилчдын үндсэн цалин, нэмэгдэл цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчдын цалин, нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн нийлбэрээс 15.1%-иар бодож төсөвт тусгах, Авто тээврийн зардлыг “Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ”-ийн дагуу тус тус тооцно.

3. Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дүгээр зүйлд заасны дагуу ажил олгогч (компани)-ийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг зам барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер, техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11.7%-иар Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу “Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал”-ын шимтгэлийн хувь хэмжээг 2.8%-иар нийт 14.5%-иар тооцно.

4. ЗТАЖ-ын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу удирдлагын зардлыг нийт цалингийн сангийн 63.5%-иар, ашгийн хэмжээг цалингийн сангийн 71.8%-иар тооцно

5. Захиалагчийн хяналтын зардлыг төсвийн 2%, магадалшгүй ажлын зардлыг шууд зардлын дүнгээс 2%, нэмэгдсэн өртгийн албан татварыг “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтын дагуу барилга угсралтын ажлын зардлын дүнгээс 10%-иар тооцно.

6. ХАБЭА-н үйл ажиллагааны зардлыг шууд зардлын дүнгээс 2.5%-иар тооцно, энэ зардал нь “Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм”-ийн дагуу замын барилгын ажлын туршид хийгдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал юм.

7. Норм, нормативын санг 0.4%-иар тооцно.

8. Үнийн тарифыг ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

9. Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын мэргэшсэн инженертэй байх.

## Ажлын тоо хэмжээ

### АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

**ТҮР БАРИЛГА БА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-01-01 | Гэр барих | 1 гэр | 3.0 |
| 2 | 25-01-02 | Бие засах газар байгуулах (3.0x2.5x2.0м) | 1 ш | 2.0 |
| 3 | 25-01-04 | Дугуйтай зөөврийн сууц байрлуулах | 1 ш | 1.0 |
| 4 | 25-01-03 | Ажилтнуудын зөөврийн сууц байрлуулах | 1 ш | 3.0 |
| 5 | 25-01-05 | Гал тогооны зөөврийн байр байрлуулах | 1 ш | 1.0 |
| 6 | 25-01-06 | Усны нөөцийн сав байрлуулах | 1 ш | 1.0 |
| 7 | 25-01-08 | Контейнер байрлуулах (агуулахын зориулалттай, 40 тн) | 1 ш | 1.0 |
| 8 | 25-01-10 | Шатахууны агуулах сав байрлуулах (50 тн) | 1 ш | 1.0 |
| 9 | 25-01-12 | Оффисын зөөврийн байр байрлуулах | 1 ш | 1.0 |
| 10 | 25-01-14 | Лабораторийн зөөврийн байр байрлуулах | 1 ш | 1.0 |

**ЗАМЫН ЧИГ СЭРГЭЭХ, ГАДАСЛАХ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-02-02 | Замын чиг сэргээх (GPS) | 1 км | 2.1 |

**ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 26-10-25 | Цементбетон хучилт молотоктой экскаватороор эвдэж хуулж ачих | 1 м3 | 2,539.2 |
| 2 | 26-05-24 | Явган хүний замын хуучин хавтанг хуулж зайлуулах | 1 м2 | 3,015.0 |
| 3 | 26-05-25 | Явган хүний замын хуучин хашлагыг хуулж зайлуулах | 1 м | 2,680.0 |
| 4 | 26-05-22 | Замын хуучин хашлагыг механизмаар хуулж зайлуулах | 1 м | 200.0 |

**МАТЕРИАЛЫН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН АЖИЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-03-01 | Хөрсний шинжилгээ | 1 удаа | 5.0 |
| 2 | 25-03-02 | Битумэн хольцын шинжилгээ | 1 удаа | 2.0 |
| 3 | 25-03-03 | Элсний шинжилгээ | 1 удаа | 2.0 |
| 4 | 25-03-04 | Чулууны шинжилгээ | 1 удаа | 2.0 |
| 5 | 25-03-08 | Асфальтбетоны орц тогтоох | 1 удаа | 2.0 |
| 6 | 25-03-10 | ЦБС-ийн орц тогтоох (СТВ) | 1 удаа | 2.0 |
| 7 | 25-03-11 | Буталсан чулуун суурийн орц тогтоох | 1 удаа | 2.0 |
| 8 | 25-03-05 | Цементийн шинжилгээ хийх | 1 удаа | 1.0 |

**ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-04-04 | Далангийн ул хөрс тэгшлэх, нягтруулах (уулзвар, гарц тоо хэмжээ орсон) | 1 м2 | 20,760.66 |
| 2 | 25-07-12 | Тохиромжгүй материал ухаж ачиж, зайлуулах (экскаватороор) | 1 м3 | 28,395.43 |
| 3 | 25-07-05 | Шороон ордоос зөөврөөр далан байгуулах | 1 м3 | 28,400.26 |

**ЗАМЫН СУУРИЙН АЖИЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-07-08 | Хөлдөлтөөс хамгаалах үе байгуулах | 1 м3 | 13,493.61 |
| 2 | 25-08-08 | Газар дээр нь холих аргаар цементээр бэхжүүлсэн зохист найрлага бүхий элс хайрган хольцоор суурь байгуулах | 1 м3 | 4,757.04 |

### ЗАМЫН ХАШЛАГА БАЙРЛУУЛАХ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-09-02 | Замын хашлага байрлуулах (1.0 x 0.3 x 0.18 м) | 1 м | 4,770.0 |

### ЗАМЫН ХУЧИЛТЫН АЖИЛ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-10-04 | Халуун асфальтбетон хольцоор суурь үе байгуулах h=4см | 1 м3 | 940.26 |
| 2 | 25-10-01 | Шингэн цацлага хийх (Prime coat) | 1 м2 | 21,369.66 |
| 3 | 25-10-05 | Халуун асфальтбетон хольцоор өнгө үе байгуулах h=3см | 1 м3 | 685.1 |
| 4 | 25-10-02 | Шингэн түрхлэг хийх (Tack coat) | 1 м2 | 20,760.66 |

### ЗАМЫН ХАЙРГАН ХӨВӨӨ БАЙГУУЛАХ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-11-01 | Хайрган хөвөө механизмаар байгуулах (Хучлага хийсний дараах асгамал хөвөө) | 1 м3 | 6,720.0 |

### ЗАМЫН УС ЗАЙЛУУЛАХ ЭНГИЙН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-12-09 | Хажуу налууд чулуун бэхэлгээ хийх h=15см ф500 хоолойноос 2-р тийшээ 10м бэхэлгээ | 1 м2 | 220.0 |
| 2 | 25-22-17 | Ус зайлуулах ган хоолой байрлуулах ф300 | 1 м | 30.0 |
| 3 | 28-16-01 | Хоолойн суурийн ухмал Ф300 | 1 м3 | 45.0 |
| 4 | 28-16-02 | Хоолойн ул суурь нягтруулах Ф300 | 1 м2 | 30.0 |
| 5 | 28-16-03 | Хоолойн суурийг зохистой ширхэглэл бүхий элс хайргаар байгуулах h=15см | 1 м3 | 4.5 |
| 6 | 28-16-17 | Буцаан дүүргэлт хийх ф300 | 1 м3 | 45.0 |
| 7 | 28-16-18 | Урсгалын хэвгийг экскаватороор засах ф300 | 1 м3 | 10.0 |

### АВТО ЗАМЫН ГАДАРГУУН УС ЗАЙЛУУЛАХ ЛОТКИ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-22-12 | Замын гадаргуугийн ус зайлуулах сувгийн тэвш байрлуулах (УЗС-1-1) 500x300x180 | 1 м | 711.0 |
| 2 | 25-13-01 | Зохист найрлага бүхий элс хайрган хольцоор суурь байгуулах h=15см | 1 м3 | 26.66 |
| 3 | 25-12-08 | Хажуу налууг бетоноор бэхлэх | 1 м2 | 42.66 |
| 4 | 28-16-14 | Гарах хэсгийн чулуун бэхэлгээ хийх | 1 м3 | 23.7 |

### УС, ДУЛААНЫ ШУГАМЫГ ХҮЧИТГЭХ АЖИЛ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-07-02 | Экскаватораар ухмал байгуулах | 1 м3 | 192.96 |
| 2 | 28-16-02 | Ул суурь нягтруулах | 1 м2 | 147.2 |
| 3 | 28-23-04 | Тулц бетоны угсармал хэсэглэл суурин дээр байгуулах ОП-2 | 1 м | 134.0 |
| 4 | 25-22-13 | Хамгаалах сувгийн тэвш байрлуулах Лотки-2 | 1 м | 134.0 |
| 5 | 28-16-12 | Түрхмэл ус тусгаарлагч хийх | 1 м2 | 201.7 |
| 6 | 28-16-17 | Буцаан дүүргэлт хийх | 1 м3 | 144.72 |

### ЯВГАН ХҮН БА УНАДАГ ДУГУЙН ЗАМЫН АЖИЛ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-13-03 | Явган хүн замын суурийг цементээр бэхжүүлсэн зохист найрлага элс хайрган хольцоор байгуулах h=3см | 1 м3 | 606.686 |
| 2 | 25-13-05 | Явган хүн ба унадаг дугуйн замын хашлага | 1 м | 7,946.0 |

**ЯВГАН ХҮН БА УНАДАГ ДУГУЙН ЗАМЫН АЖИЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 3 | 25-14-05 | байрлуулах | 1 м2 | 6,124.53 |
| 4 | 25-13-06 | Явган хүний хөтөч хавтанг зориулалтын будгаар хийх | 1 м3 | 266.94 |
| 5 | 25-16-03 | Явган хүн ба унадаг дугуйн замын хучилга халуун асфальтбетон хольцоор гараар байгуулах h=4см | 1 м2 | 3,459.69 |
| 6 | 25-10-01 | Зүлэгжүүлэх | 1 м2 | 6,300.0 |
| | | Шингэн цацлага хийх (Prime coat) | | |

**ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ АЖИЛ БА ЗАМЫН ТОНОГЛОЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-14-03 | Замын тэмдэглэгээг зориулалтын машинаар термопластик будгаар хийх | 1 м2 | 1,229.497 |
| 2 | 25-15-01 | Замын тэмдэг суурилуулах | 1 ш | 241.0 |
| 3 | 25-15-03 | Дохионы төмөрбетон шон суулгах | 1 ш | 4.0 |
| 4 | 25-15-06 | Явган хүний замын тусгаарлах хайс угсрах | 1 м | 1,064.5 |

**ХУРД СААРУУЛАГЧ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-22-07 | Хурд сааруулагч байгуулах (Асфальтбетон хольцоор) | 1 м3 | 44.8 |
| 2 | 25-14-03 | Хурд сааруулагчийн тэмдэглэл хийх | 1 м2 | 443.8 |

**АЙЛРУУ ОРЖ, ГАРАХ ГАРЦ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-10-16 | Халуун асфальтбетон хольцоор хучилга гараар байгуулах (жижиг тохижилтын ажилд) h=5см | 1 м3 | 11.45 |
| 2 | 25-10-16 | Халуун асфальтбетон хольцоор хучилга гараар байгуулах (жижиг тохижилтын ажилд) h=3см | 1 м3 | 0.55 |
| 3 | 25-14-05 | Хөтөч хавтан зориулалтын (Термопластик) | 1 м2 | 3.6 |

**ХОС Ф500 ГАН ХООЛОЙН ТОО ХЭМЖЭЭ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 28-16-01 | Хоолойн суурийн ухмал | 1 м3 | 114.3 |
| 2 | 25-22-17 | Ус зайлуулах ган хоолой байрлуулах | 1 м | 24.0 |
| 3 | 28-16-02 | Хоолойн ул суурь нягтруулах | 1 м2 | 88.02 |
| 4 | 28-16-03 | Хоолойн суурийг зохистой ширхэглэл бүхий элс хайргаар байгуулах h=10см | 1 м3 | 3.36 |
| 5 | 25-24-33 | Бетон хамгаалалт хийх B20 | 1 м3 | 3.36 |
| 6 | 28-18-04 | Хоолойн далбаа, толгойн хэсэглэл цутгах B25 | 1 м3 | 4.2 |
| 7 | 25-24-33 | Бетон шал цутгах B20 h=10см | 1 м3 | 3.36 |
| 8 | 28-16-12 | Түрхмэл ус тусгаарлагч хийх | 1 м2 | 74.4 |
| 9 | 28-16-14 | Орох гарах хэсгийн толгойн чулуун бэхэлгээ хийх B15 h=20см | 1 м3 | 1.47 |
| 10 | 28-16-14 | Орох гарах хэсгийн бэхэлгээ B20 h=20см | 1 м3 | 1.8 |
| 11 | 28-16-14 | Орох гарах хэсгийн чулуун бэхэлгээ B15 h=20см | 1 м3 | 6.0 |
| 12 | 28-16-17 | Буцаан дүүргэлт хийх | 1 м3 | 114.3 |
| 13 | 28-16-18 | Урсгалын хэвгийг экскаватороор засах | 1 м3 | 40.0 |

**ҮЙЛДВЭР, ЗАВОДЫГ АЧИЖ БУУЛГАХ, УГСРАХ, ХУРААХ АЖИЛ**

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-23-01 | Асфальтбетон хольцын үйлдвэр автомашинд ачиж буулгах, угсрах, хураах ажил | 1 ком | 1.0 |
| 2 | 25-23-04 | Чулуу бутлан ангилах үйлдвэр авто машинд ачиж | 1 ком | 1.0 |

ҮЙЛДВЭР, ЗАВОДЫГ АЧИЖ БУУЛГАХ, УГСРАХ, ХУРААХ АЖИЛ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| | | буулгах, угсрах, хураах ажил | | |

ОБЪЕКТИЙГ АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ

| № | Үндэслэл | Ажлын нэр | Хэмжих нэгж | Ажлын тоо хэмжээ |
|---|---|---|---|---|
| 1 | 25-19-02 | Зам ашиглалтад өгөх үеийн хог цэвэрлэх | 1 км | 2.1 |
| 2 | 25-20-02 | Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах | 1 км | 2.1 |

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:**

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА /Ц.МӨНХЭРДЭНЭ/

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:**

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН: /Н.БЯМБАЦЭЦЭГ/